



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 683
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Бямбажавын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021378

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Бямбажав Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Бямбажавын мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Б.Бямбажавт

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Баян-Агт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны ээлжит Сонгуулийн 3-р хэсэгт
Бие даан нэр дэвшигч Бат-Очирын БЯМБАЖАВын
“НЭЭЛТТЭЙ, ОРОЛЦООТОЙ БАЯН-АГТ” мөрийн хөтөлбөр

Нээлттэй оролцоотой засаглалтай, Амгалан тайван амьдрах орчинтой, Эрүүл мэнд ба Боловсролыг эрхэм болгосон, Ажилтай орлоготой Баян-Агтчууд

1. НЭЭЛТТЭЙ, ОРОЛЦООТОЙ ЗАСАГЛАЛ

**Төрийн байгууллагын удирдлага,
төрийн албан хаагч нарын манлайллыг бий болгох**

- 1.1 Нээлттэй мэдээлэл, харилцаа холбоо, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх,
- 1.2 Нээлттэй, оролцоотой төлөвлөлт, төсөв, хөрөнгө оруулалт, хяналт, үнэлгээг бий болгох,
- 1.3 Нээлттэй үнэлгээ, сэтгэл ханамж, тайлан мэдээллийг бий болгох,
- 1.4 Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлаг соёлын бүхий л чиглэлийн болон бүхий л шатлалын төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллах,
- 1.5 Ард иргэдийг чирэгдүүлэхгүй байхад төрийн үйлчилгээг чиглүүлэх, орлох, хариуцах, бүгд мэддэг байх ба тусалдаг зарчмыг бий болгож хэвшүүлэх,

6317144793
ГЮА0048 3190269

2. АМГАЛАН ТАЙВАН АМЬДРАХ ОРЧИН

- 2.1 Хүнд ээлтэй, байгальд ээлтэй төлөвлөлт, бүтээн байгуулалтыг эрхэмлэх,
- 2.2 Архи, тамхины хэрэглээг бууруулах, хуулийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх,
- 2.3 Онцгой нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авах чадавхийг сайжруулах,
- 2.4 Орон байрны хулгай, ахуйн хулгай, малын хулгай зэрэгтэй иргэд, сум ба аймгийн цагдаагийн нэгжтэй нягт хамтран тэмцэх,
- 2.5 Үерийн далан, суваг шуудуу хийх судалгааны ажил хийлгэх,
- 2.6 Зам, гүүрний засвар, ашиглалтанд тогтмол анхаарах,
- 2.7 Газар тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах,
- 2.8 Рашаан түшиглэсэн амралтын газруудын байгаль орчинд дахь сөрөг нөлөөллийг бууруулахад ямагт анхааран ажиллах,

3. ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ

- 3.1 Боловсролын байгууллагуудын удирдлага, менежментийг сайжруулах,
- 3.2 Сурагчдын олимпиад, тэмцээний оролцоо, амжилтыг жил бүр нэмэгдүүлэн ахиулах,
- 3.3 Боловсролын чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэх, бүхий л түвшний байгууллагуудтай идэвхитэй хамтран ажиллах,
- 3.4 Сумын соёлын төв, номын санг иргэд, хүүхдүүдийн байнгын үйлчлүүлдэг газар болгох,
- 3.5 Эмийн чанар, аюулгүй байдал, үнэ өртөгт хяналт тавих,

- 3.6 Хүнсний бараа бүтээгдэхүүний эрүүл ахуйд тогтмол хяналт тавих,
- 3.7 Төрөөс үзүүлж буй хөнгөлөлт, халамж, дэмжлэг бүрийг шаардлагатай иргэн, өрх бүрт хүртээмжтэй хүргэх /ЭМД, татварын хөнгөлөлт, буцаалт г.м/
- 3.8 Хүүхэд, залуучууд цагаа зөв боловсон өнгөрүүлэх талбай, орчинг бүрдүүлэхэд анхаарч хамтран ажиллах,

4. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ АМЬДРАЛ

- 4.1 Шудрага өрсөлдөөнийг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажлыг хуулийн хүрээнд тогтмол чанд зохион байгуулах,
- 4.2 НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад дэмжин ажиллах,
- 4.3 Амралтын газар, байгалийн үзэсгэлэнт газар, ховор сонин тогтоцод түшиглэсэн ажлын байр нэмэгдүүлэх, орлого олох бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжин ажиллах,
- 4.4 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, бойжуулах, тасралтгүй сайжран ажиллахад тогтвортой бодлогоор дэмжин ажиллах,
- 4.5 Сайн үүлдэр, угсааны эцэг болон эх мал суманд авч ирэх аж ахуйн нэгж, иргэдийн санаачилга, ажлыг шаардлагатай мэдээллээр ханган байнга дэмжиж ажиллах,

6317144798
ГЮА0048 3190269

**НЭЭЛТТЭЙ, ОРОЛЦООТОЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ,
ХӨГЖИЛ ДЭВШИЛД ТЭМҮҮЛСЭН БАЯН-АГТ СУМ**